

ТАНИЛЦУУЛГА

Хүнсний гол нэрийн барааны үнэ,
2017 оны 10-р сарын 25-ны байдлаар


2017 оны 10-р сарын 25-ны байдлаар гол нэрийн барааны үнийг өмнөх сартай харьцуулахад 3.9 хувь, өмнөх 7 хоногтой харьцуулахад 0.7 хувиар буурсан байна.

Махны дундаж үнэ: 2017 оны 10-р сарын 25-ны байдлаар хонины ястай махны үнэ өмнөх сараас 10.5 хувь, үхрийн ястай махны үнэ 4.8 хувь, үхрийн цул махны үнэ 1.3 хувь, ямааны ястай махны үнэ 13.5 хувь, адууны ястай махны үнэ 6.0 хувиар буурсан байна.

Өмнөх 7 хоногтой харьцуулахад хонины ястай махны үнэ өмнөх сараас 2.0 хувь, үхрийн ястай махны үнэ 0.2 хувь, үхрийн цул махны үнэ 0.3 хувь, ямааны ястай махны үнэ 9.4 хувь, адууны ястай махны 2.5 хувиар буурсан байна.

2017 оны 10-р сарын 25-ны байдлаар 1 кг хонины /ястай/ мах дунджаар 5555 төгрөг, үхрийн /ястай/ мах 6900 төгрөг, үхрийн цул мах 8265 төгрөг, адууны /ястай/ мах 4900 төгрөг, ямааны /ястай/ мах 3835 төгрөгийн үнэтэй байв (Зураг 1).

Зураг 1. Ястай махны жижиглэн худалдааны дундаж үнэ




Гурилын үнэ: 2017 оны 10-р сарын 25-ны байдлаар гурилын үнийг өмнөх сарынхтай болон өмнөх 7 хоногтой харьцуулахад өөрчлөлтгүй байна.

Будаа, элсэн чихрийн дундаж үнэ: 2017 оны 10-р сарын 25-ны байдлаар цагаан будааны үнэ өмнөх сарынхтай харьцуулахад 0.4 хувиар өсч, өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад өөрчлөлтгүй байна.

Элсэн чихрийн үнэ өмнөх сарынхтай харьцуулахад 0.3 хувиар өсч, өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад өөрчлөлтгүй байна. (Зураг2).

Зураг 2. Цагаан будаа, элсэн чихэр, төмсний дундаж үнэ



Төмс, хүнсний ногооны дундаж үнэ: 2017 оны 10-р сарын 25-ны байдлаар төмс, хүнсний ногооны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад төмсний үнэ 3.1 хувь, луувангийн үнэ 26.2 хувь, байцааны үнэ 2.0 хувь, сонгины үнэ 0.9 хувиар буурч, хүрэн манжингийн үнэ өөрчлөлтгүй байна.

Өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад төмс, хүнсний ногооны үнэ өөрчлөлтгүй байна.

Сүү, өндөг, ургамлын болон цөцгийн тосны дундаж үнэ: 2017 оны 10-р сарын 25-ны байдлаар сүүний үнийг өмнөх сарынхтай харьцуулахад задгай сүүний үнэ 1.8 хувиар буурч, “Элекстер” /0.5 литрийн/ сүүний үнэ 0.8 хувь, савласан /1 литрийн/ сүүний үнэ 4.7 хувиар өссөн байна. Өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад сүүний үнэ өөрчлөлтгүй байна.

Өндөгний үнэ өмнөх сарынхтай харьцуулахад 0.4 хувиар буурч, өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад өөрчлөлтгүй байна.

Ургамлын тосны үнэ өмнөх сарынхаас болон өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байна.

Цөцгийн тосны үнэ өмнөх сарынхтай болон өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад өөрчлөлтгүй байна.

**ҮСХ-ны Эдийн засгийн статистикийн газар
2017 оны 10-р сарын 25**